

1467



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1995 оны 11 дугаар сарын 09 өдөр

Дугаар А/244

Улаанбаатар хөт

## Дүрэм батлах тухай

Нэг. Төрийн Хяналт шалгалтын тухай Монгол Улсын хууль, Засгийн газрын 1995 оны 157 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны хяналтын дүрэм"-ийн дагуу захиргааны хяналт шалгалтыг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан Тамгын газрын хянан байцаах хэлтсийн дүрмийг хавсралт N 1-ээр шинэчлэн баталсугай.

Хоёр. Энэ дүрмийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Н.Болдсайхан)-д даалгасугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Тамгын газрын дотоод журам, хэлтэс, тасгийн дүрэм батлах тухай" Нийслэлийн Засаг даргын 1993 оны 11 дүгээр сарын 4-ний А\244 тоот захирамжийн 3 дугаар хавсралтыг хүчингүй болгонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БОГСОД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

*Ц.Баасанжав*

Ц. БААСАНЖАВ

Нийслэлийн Засаг даргын 1995 оны А\242 тоот захирамжаар батлав.

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАН БАЙЦААХ ХЭЛТСИЙН ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Төрийн захиргааны хяналтыг Нийслэлийн хэмжээнд зохион байгуулж хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хууль, тогтоомжид нийцүүлэн Засгийн газрын 1995 оны 157 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны хяналтын дүрэм", мөн энэхүү дүрмийг удирдлага болгоно.

2. Төрийн захиргааны хяналт нь Монгол Улсын хууль, тогтоомж Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэр, Засаг даргын захирамж, нийслэлийн хэмжээнд дагаж мөрдүүлэхээр батлан гаргасан журам, дүрмийг албан байгууллага, аж ахуйн нэгжид харьяалал, өмчийн ялгаа харгалзахгүйгээр хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

3. Нийслэл, дүүргүүдийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, тамгын газар, захирагчийн алба, тэдгээрийн газар, хэлтэс, салбар, улмаар хороод нь өөрсдийн үйл ажиллагаагаараа захиргааны дотоодын хяналт шалгалтыг хэрэгжүүлэн гүйцэтгэнэ.

4. Төрийн захиргааны хяналт шалгалтыг эрхлэн гүйцэтгэх алба нь Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хянан байцаах хэлтэс байна.

Хянан байцаах хэлтэс нь нийслэлийн хэмжээнд захиргааны хяналт, салбарын мэргэжлийн хяналт шалгалтыг уялдуулан зохицуулна.

**Хоёр. Хянан байцаах хэлтсийн үүрэг**

1. Хянан байцаах хэлтэс нь Монгол Улсын хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр болон Засаг даргын захирамж, нийтээр дагаж мөрдүүлэхээр батлан гаргасан дүрэм, журмын биелэлтийг хянан шалгах, дүгнэж, тооцох ажлыг нутаг дэвсгэртээ оршдог байгууллага, аж ахуйн нэгж өөрийн аппаратын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг зохих журмын дагуу гаргаж мэдээллэх ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

2. Хянан байцаах хэлтэс нь сахилга, дэг журмыг бэхжүүлэх, хууль ёсыг сахиулах асуудлаар байгууллага, аж ахуйн нэгжид үүрэг даалгавар өгч, биелэлтийн явцад хяналт тавьж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах үйл ажиллагааг явуулна.

3. Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Захирагчийн албаны харьяа газар, хэлтэс, тасаг, салбар, байгууллагуудаас хууль тогтоомж, захирамж, шийдвэрийн биелэлтийг ханган, дүрмээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж, үйлдвэрлэл үйлчилгээний чанар, ариун цэвэр тохижилт соёлчилт, дэг журмыг дээшлүүлж байгаа байдалд хяналт тавьж илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран боловсруулж хуралд оруулж хэлэлцүүлэн, заалт шийдвэр гаргаж ажиллана.

4. Нийслэлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг захиргааны мэргэжлийн хяналтын тогтолцоо, бүтцийг бүр-

дүүлж боловсронгуй болгох ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Энэ арилгоор захиргааны хяналтыг эрхлэн явуулж буй байгууллага албадаас тухайн жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг авч үзэж үйл ажиллагааны давхардлыг арилгах чиглэлээр зохицуулалт хийж хотын амьдралын тулгамдсан гол асуудлуудад хүч анхаарлыг төвлөрүүлэх нэгдсэн графикаар хамтарсан шалгалт хийх, хяналт шалгалтын тайлан мэдээ, судалгаанд дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулах, улсын байцаагч болон захиргааны хяналтын ажилтнуудад арга зүйн туслалцаа үзүүлэх.

5. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хот, дүүргүүдийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг хийгээд гаргасан шийдвэрийн биелэлт, явц, үр дүнд хяналт тавьж дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна.

6. Хөдөлмөрчдөөс ирүүлсэн захидал, мэдээлэл, өргөдөл, гомдол санал хүсэлтийг харъяаллын дагуу хүлээн авч хөнгөн шуурхай барагдуулж ажиллах.

#### Гурав. Хянан байцаах хэлтсийн эрх

1. Монгол Улсын хууль тогтоомж, Нийслэлийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирмж, өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, хяналт шалгалтын явцад илэрсэн дутагдлыг арилгуулах, ажил сайжруулах талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага тавьж гүйцэтгэлийг хангуулах.

2. Хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг тодорхой хугацаагаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулж авах.

3. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хүмүүсийг зохих байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр ажлын 7 хүртэл хоногийн хугацаагаар үүрэгт ажлаас нь чөлөөлүүлж, шалгалтын ажилд оролцуулах. Энэ тохиолдолд тэдгээрийн хяналт шалгалтын ажилд оролцсон хугацааны цалин, томилолтын зардлыг үндсэн байгууллага нь олгоно.

4. Үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, гэм буруутай нь шалгалтаар нотлогдсон албан тушаалтанд төрийн албаны болон захирны хариуцлагын хуульд заасан шийтгэл ногдуулах, эрүүгийн гэмт хэргийн тохиолдолд холбогдох баримт материалыг хуулийн байгууллагад харъяаллын дагуу шилжүүлэх.

5. Хууль тогтоомж, захирамж журмыг зөрчсөнөөс болон биелүүлээгүйгээс байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг улсын орлогод оруулах, мөн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

6. Хийсэн шалгалтаас гаргасан дүгнэлт, оршиж байгаа дутагдал зөрчил, түүнийг арилгах талаар авах арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх ажлын тухай шийдвэрийн төсөл, саналыг Нийслэлийн Засаг дарга түүний орлогч, тамгын газрын даргад танилцуулан шаардлагатай бол Засаг даргын зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэх.

7. Хяналт шалгалтын дүнг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байх.

Хянан байцаах хэлтсийн улсын байцаагч нарын өгсөн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзвэл байгууллага, иргэд энэ тухай гомдлоо Нийслэлийн Тамгын газарт гаргаж болно. Уг гомдлыг хүлээж авсанаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж хариу өгнө.

Тамгын газраас өгсөн хариуг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу дээд шатны болон хуулийн байгууллагад гаргаж болно.

Дөрөв. Төрийн захиргааны хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэг

1. Улсын байцаагч нь хууль тогтоомжийг чанд сахих хөндлөнгийн нөлөөнд үл автан үүргээ үнэнчээр гүйцэтгэх, төр, байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, хяналт шалгалтыг бүрэн хийх үүрэгтэй.

Улсын байцаагч нь хийсэн шалгалт, гаргасан дүгнэлт, албан шаардлага, тоо баримтын үндэслэл нотолгооны үнэн зөвийг хариуцна.

2. Монгол Улсын хууль, тогтоомж, захирамж шийдвэр, тусгайлан баталж гаргасан дүрэм, журмын хэрэгжилт, сахилга хариуцлагын байдалд хяналт тавьж, Нийслэлийн төр, захиргаа, албан байгууллага, аж ахуйн нэгжид саадгүй нэвтрэн орж шалгалт хийнэ.

3. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлын талаар амаар буюу бичгээр тайлбар авах, эд хөрөнгийн зүйлийг хадгалаж байгаа агууллахад орж шалгах, бүтээгдэхүүний дээж загварыг авч шинжлүүлэх, холбогдох баримт бичгийг үзэж танилцаж, илэрсэн зөрчил, дутагдалд зохих хууль журмын дагуу торгууль, төлбөр ногдуулах.

4. Хүрээлэн буй орчин, хүний амь нас, эрүүл мэндэд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон тохиолдолд үйлдвэрлэл үйлчилгээг зогсоох бүтээгдэхүүнийг худалдах, борлуулахыг хориглох, улмаар уг зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, бусад баримт материалыг хуулийн байгууллагад шилжүүлэх.

Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар байгууллага, аж ахуйн нэгж, холбогдох албан тушаалтанд шаардлага тавьж хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах.

6. Хянан байцаах хэлтсийн дарга нь улсын ахлах байцаагч байна. Улсын ахлах байцаагчийг Нийслэлийн засаг дарга томилж, чөлөөлнө. Хэлтсийн ажилтнууд нь улсын байцаагч байх ба Тамгын газрын дарга томилж, улсын байцаагчийн эрхийг Нийслэлийн засаг дарга олгоно.

Улсын байцаагч нь Засгийн газраас батлагдсан загварын дагуу хийсэн албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг түүнчлэн албан шаардлага, дүгнэлт, акт, торгууль, шийтгэврийн хэвэлмэл хуудас хэрэглэнэ. Улсын ахлах байцаагч нь "Төрийн хяналт шалгалтын тухай" Монгол Улсын хуулийн 27 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1,5-д заасны дагуу хяналт шалгалтаас зайлсхийсэн албан тушаалтыг 5000-15000 хүртэл төгрөгөөр торгох болон захиргааны хариуцлагын шийтгэл ногдуулах эрхийг эдэлнэ.

Улсын байцаагч нь Монгол Улсын хууль тогтоомжид заасан ажиллах баталгаагаар хангагдаж, төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг ёсчлон дагаж биелүүлэн захиргааны хяналтын улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхийг эдэлнэ.

Улсын байцаагч нь үүрэгд ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль, тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

НИЙСЛЭЛИЙН ТАМГЫН ГАЗАР

ОЮУ